# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 25 өдөр | Дугаар 24 | Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, “Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 21 дүгээр тогтоол, Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 38 дугаар тогтоол, 2022 оны 63 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дархан-Уул аймгийн өмчөөс болон хувийн хэвшлийн иргэн, аж ахуйн нэгжээс үнэ төлбөргүй шилжүүлсэн, 18 нэрийн, нийт 2,040,887,533.10 (хоёр тэрбум дөчин сая найман зуун наян долоон мянга таван зуун гучин гурван төгрөг арван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.“Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Батжаргал, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Баасанжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

123007406

2-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 01 дүгээр сарын ...18...-ны өдрийн
...34..... дугаар тогтоолын хавсралт

"ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Хөрөнгийн нэр | Байршил | Ашиглалтад орсон огноо | Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн дугаар | Марк, хүчин чадал | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Бүртгэх дүн (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Дархан-Уул аймгийн өмчөөс шилжүүлсэн хөрөнгийн жагсаалт** | | | | | | | | |
| 1 | Гадна дулааны далд шугам | Дархан-Уул, Дархан сум, 1 дүгээр баг | 2022.10.28 | 28/2022-Д | Ф219*2 | м | 790 | 633,164,553.95 |
| 2 | Гадна дулааны ил сувaггүй шугам | Дархан-Уул, Дархан сум, 1 дүгээр баг | | | Ф159*2 | м | 494 | 210,255,632.00 |
| 3 | Гадна дулааны далд сувагт шугам | Дархан-Уул, Дархан сум, 1 дүгээр баг | | | Ф108*2 | м | 79 | 43,255,102.00 |
| 4 | Гадна дулааны цутгамал бетон худаг | Дархан-Уул, Дархан сум, 1 дүгээр баг | | | - | Иж бүрэн | 6 | 43,460,277.15 |
| 5 | Ус дулаан дамжуулах төв (Дархан-Уул, Дархан сум, 1-р баг) | Барилга | 2022.11.28 | 31/2022-Д | Халаалт 1860 кВт, ХХУс-1465 кВт | ш | 1 | 153,220,918.00 |
| 6 | | Дулаан механикийн тоноглол (ялтсан бойлер) | | | | ком | 1 | 198,283,824.00 |
| 7 | Насос станц (Дархан-Уул, Дархан сум, 1-р баг) | Даралт өргөх насосны барилга | | | ТР80-110/4 | | | |
| 8 | | Даралт өргөх насосны тоноглол | | | | ком | 1 | 25,386,808.00 |
| 9 | Ус дулаан дамжуулах төвийн барилга -1 /гадна дулаааны шугам/ | Дархан-Уул, Дархан сум 13 дугаар баг, Их сургуулийн гудамж | 2020.05.21 | 07/2020-Д | /9*12м2, ф159*2-22м/ | ш | 1 | 215,701,812.00 |
| 10 | Ус дулаан дамжуулах төвийн барилга -2 /гадна дулаааны шугам/ | Дархан-Уул, Дархан сум 13 дугаар баг, Их сургуулийн гудамж | | | /9*12м2, ф159*2-80м/ | ш | 1 | 259,757,282.00 |
| Хэсгийн дүн | | | | | | | 1374 | 1,782,486,209.10 |

| Д/д | Хөрөнгийн нэр | Байршил | Ашиглалтад орсон огноо | Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн дугаар | Марк, хүчин чадал | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Бүртгэх дүн (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Хувийн хэвшлийн иргэн, аж ахуй нэгжээс үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийн жагсаалт** | | | | | | | | |
| 11 | Гадна дулааны шугам | Дархан-Уул, Дархан сум,14-р баг “Нэхий Агр” ХХК-ийн 45а нийтийн зориулалттай орон сууцны барилга | 2019.12.17 | №03/2019-II | Ф133*2 | м | 75 | 22,500,000.00 |
| 12 | Ялтсан халаагч бүхий дулааны узел | | | | | Иж бүрэн | 1 | 25,000,000.00 |
| 13 | Гадна дулааны шугам | Дархан-Уул аймаг, Дархан сум, 14-р баг “Нэхий Агр” ХХК-ийн 45б /302/ нийтийн зориулалттай орон сууцны барилга | 2015.12.30 | №2015/24-II | Ф133*2 | м | 118 | 41,300,000.00 |
| 14 | Ялтсан халаагч бүхий дулааны узел | | | | | Иж бүрэн | 1 | 25,000,000.00 |
| 15 | Гадна дулааны шугам | Дархан-Уул аймаг, Дархан сум, 8-р баг, 17-р хороолол, “Өгөөж гурил” ХХК-ийн 79 айлын нийтийн зориулалттай орон сууцны барилга | 2022.07.01 | 16/2022-Д | Ф108*2 | м | 350 | 30,128,610.00 |
| 16 | Ялтсан халаагч бүхий дулааны узел | | | | Халаалт 300 кВт, ХХУс- 380 кВт | Иж бүрэн | 1 | 80,212,714.00 |
| 17 | Гадна дулааны шугам шугам, тоноглол | Дархан-Уул аймаг, Дархан сум, 15-р баг, Хүрээлэнгийн 1 | | | | м | 161.6 | 19,260,000.00 |
| 18 | Ялтсан халаагч бүхий дулааны узел | Дархан-Уул аймаг, Дархан сум, 15-р баг, Хүрээлэнгийн 1 | | | 650 кВт | Иж бүрэн | 1 | 15,000,000.00 |
| Хэсгийн дүн | | | | | | | 2067.6 | 258,401,324.00 |
| Нийт дүн | | | | | | | 3441.6 | 2,040,887,533.10 (хоёр тэрбум дөчин сая найман зуун наян долоон мянга таван зуун гучин гурван төгрөг арван мөнгө) |